ERDENE
RESOURCE DEVELOPMENT

# ХУРААНГУЙ, ЗАВСРЫН ҮЕИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2024 болон 2025 оны 6 сарын 30-ны өдөр дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

*(Канад доллараар)*
*(Аудитаар баталгаажаагүй)*

Удирдлага бэлтгэв – Уншигчдад хүргүүлэх мэдэгдэлтэй танилцана уу

# УНШИГЧДАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ

National Instrument 51-102 Мэдээллийн ил тод байдлын үүрэг хариуцлага, 4-р хэсэг, 4.3 (3) а-д заасны дагуу хэрэв хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайланг аудитор хянан, баталгаажуулаагүй тохиолдолд энэхүү мэдэгдлийг хавсаргах үүрэг хүлээдэг. Энэхүү аудитаар баталгаажаагүй завсрын үеийн нэгтгэсэн хураангуй тайланг Компанийн удирдлага бэлтгэсэн. Удирдлага нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2024 оны 12 сарын 31 болон 2025 оны 6 сарын 30-ны байдлаар санхүүгийн тайланг нэгтгэн, 2024, 2025 оны 6 сарын 30-ны өдөр дуусгавар болсон гурав болон зургаан сарын нийт алдагдал, эздийн өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний мэдээллийг боловсруулсан. Компанийн хараат бус аудитор нь 2024, 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хураангуй, нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх, хянах болон ямарваа нэгэн байдлаар мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулаагүй болно. Уншигчдын зорилготой нийцэхгүй байх магадлалтай тул энэхүү мэдэгдлийг хүргүүлэв.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

**Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлан**
(Канад доллараар)
(Аудитаар баталгаажаагүй)

| | Тодруулга | | 2025.06.30 | | 2024.12.31 |
|---|---|---|---|---|---|
| **Хөрөнгө** | | | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | | $ | **5,863,001** | $ | 7,298,399 |
| Дансны авлага | | | **356,176** | | 14,910 |
| Урьдчилж төлсөн авлага | | | **253,733** | | 69,988 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | | | **6,472,910** | | 7,383,297 |
| | | | | | |
| Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт | **4** | | **47,216,553** | | 53,109,742 |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | **5** | | **2,639,176** | | 2,468,070 |
| Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж | | | **38,588** | | 39,104 |
| Хөрөнгө ашиглах эрх | | | **100,021** | | - |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | | **49,994,338** | | 55,616,916 |
| | | | | | |
| **Нийт хөрөнгийн дүн** | | **$** | **56,467,248** | **$** | 63,000,213 |
| | | | | | |
| **Өр төлбөр ба эздийн өмч** | | | | | |
| Арилжаа болон бусад өглөг | | **$** | **1,118,076** | $ | 782,851 |
| Түрээсийн өглөг | | | **23,743** | | - |
| Богино хугацаат өр төлбөр | | | **1,141,819** | | 782,851 |
| | | | | | |
| Түрээсийн өглөг | | | **76,678** | | - |
| Урт хугацаат өр төлбөр | | | **76,678** | | - |
| **Нийт өр төлбөрийн дүн** | | | **1,218,497** | | 782,851 |
| | | | | | |
| **Эздийн өмч** | | | | | |
| Хувьцаат капитал | **7** | **$** | **167,612,862** | $ | 165,589,487 |
| Нэмж төлөгдсөн | **7** | | **31,315,561** | | 30,656,061 |
| Хуримтлагдсан бусад орлого | | | **1,697,287** | | 2,725,582 |
| Алдагдал | | | **(145,376,959)** | | (136,753,768) |
| **Эздийн өмчийн дүн** | | | **55,248,751** | | 62,217,362 |
| | | | | | |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | | **$** | **56,467,248** | $ | 63,000,213 |

Тайлант хугацааны үйл явдлууд (Тодруулга 11)

Дагалдах тодруулгууд нь хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөх (“ТУЗ”)-ийг төлөөлж баталсан:

*Гарын үсэг зурсан “Кеннет МакДоналд”*
___________________________________ ТУЗ-ийн гишүүн

*Гарын үсэг зурсан “Лэйтон Крофт”*
___________________________________ ТУЗ-ийн гишүүн

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

**Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн алдагдлын дэлгэрэнгүй тайлан**

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажаагүй)

| | Тодруулга | 6.30-нд дуусгавар болсон гурван сар 2025 | 2024 | 6.30-нд дуусгавар болсон зургаан зар 2025 | 2024 |
|---|---|---|---|---|---|
| **Үйл ажиллагааны зардал** | | | | | |
| Хайгуул, үнэлгээний зардал | 8 | **$ 514,224** | $ 596,590 | **$ 1,487,814** | $ 1,379,746 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 9 | **658,353** | 667,030 | **2,159,208** | 3,444,618 |
| Үйл ажиллагаанаас учирсан алдагдал | | **1,172,577** | 1,263,620 | **3,647,022** | 4,824,364 |
| Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас үүдсэн алдагдал | 4 | **2,995,481** | 644,607 | **5,079,912** | 901,623 |
| Санхүүгийн орлого | | **(49,725)** | (36,996) | **(105,650)** | (86,014) |
| Хүүгийн зардал | | **723** | 136 | **723** | 404 |
| Гадаад валютын ханшийн зөрүүнээс гарсан ашиг | | **3,274** | (2,553) | **1,184** | (22,453) |
| Хараат компанийн хөрөнгө оруулалтын хорогдуулалтаас үүссэн ашиг | 4 | **-** | - | **-** | (1,070,737) |
| **Цэвэр алдагдал** | | **$ 4,122,330** | $ 1,868,814 | **$ 8,623,191** | $ 4,547,187 |
| Бусад дэлгэрэнгүй (ашиг) алдагдал: | | | | | |
| Гадаад дахь охин компанийн хөрвүүлгээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү | | **164,738** | (17,557) | **215,018** | (79,252) |
| Гадаад дахь хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын хөрвүүлгээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү | 4 | **3,506,250** | - | **813,277** | - |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | **3,670,988** | (17,557) | **1,028,295** | (79,252) |
| **Нийт дэлгэрэнгүй алдагдал** | | **$ 7,793,318** | $ 1,851,257 | **$ 9,651,486** | $ 4,467,935 |
| Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал | | **$ 0.01** | $ - | **$ 0.02** | $ 0.01 |
| Гаргасан болон эргэлтэд буй хувьцааны жигнэсэн дундаж тоо | | **364,902,837** | 346,735,996 | **363,724,223** | 345,861,866 |

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

**Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажаагүй)

| | Тодруулга | Хувьцааны тоо ширхэг | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй ашиг (алдагдал) | Алдагдал | Нийт эздийн өмч |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2025.01.01-ний үлдэгдэл** | | **362,136,958** | **$ 165,589,487** | **$ 30,656,061** | **$ 2,725,582** | **$ (136,753,768)** | **$ 62,217,362** |
| **Тайлант үеийн нийт орлого:** | | | | | | | |
| **Цэвэр алдагдал** | | **-** | **-** | **-** | **-** | **(8,623,191)** | **(8,623,191)** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | **-** | **-** | **-** | **(1,028,295)** | **-** | **(1,028,295)** |
| **Хэрэгжүүлсэн опцион** | **7** | **3,615,000** | **2,023,375** | **(599,625)** | **-** | **-** | **1,423,750** |
| **Хувьцаанд суурилсан урамшуулал** | **7** | **-** | **-** | **1,259,125** | **-** | **-** | **1,259,125** |
| **Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл, гүйлгээ** | | **3,615,000** | **2,023,375** | **659,500** | **-** | **-** | **2,682,875** |
| **2025.06.30-ны үлдэгдэл** | | **365,751,958** | **$ 167,612,862** | **$ 31,315,561** | **$ 1,697,287** | **$ (145,376,959)** | **$ 55,248,751** |
| 2024.01.01-ний үлдэгдэл | | 344,888,176 | $ 158,086,286 | $ 30,147,989 | $ (849,598) | $ (128,507,882) | $ 58,876,795 |
| Тайлант үеийн нийт орлого: | | | | | | | |
| Цэвэр алдагдал | | - | - | - | - | (4,547,187) | (4,547,187) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | - | - | - | 79,252 | - | 79,252 |
| Хэрэгжүүлсэн опцион | 7 | 2,660,000 | 876,900 | (270,900) | - | - | 606,000 |
| ИОХЭ-ийн төлөвлөгөөнөөс гаргасан хувьцаа | 7 | 883,330 | 430,182 | (32,683) | - | - | 397,499 |
| Хувьцаанд суурилсан урамшуулал | 7 | - | - | 1,401,172 | - | - | 1,401,172 |
| Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл, гүйлгээ | | 3,543,330 | 1,307,082 | 1,097,589 | - | - | 2,404,671 |
| 2024.06.30-ны үлдэгдэл | | 348,431,506 | $ 159,393,368 | $ 31,245,578 | $ (770,346) | $ (133,055,069) | $ 56,813,531 |

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг.

# ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

**Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**
(Канад доллараар)
(Аудитаар баталгаажаагүй)

| | тодруулга | 6.30-нд дуусгавар болсон гурван сар 2025 | 6.30-нд дуусгавар болсон гурван сар 2024 | 6.30-нд дуусгавар болсон зургаан сар 2025 | 6.30-нд дуусгавар болсон зургаан сар 2024 |
|---|---|---|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:** | | | | | |
| Цэвэр алдагдал | | **$ (4,122,330)** | $ (1,868,814) | **(8,623,191)** | $ (4,547,187) |
| Бэлэн бус гүйлгээнүүд | | | | | |
| Элэгдэл, хорогдол | | **5,007** | 10,255 | **7,708** | 19,278 |
| Хувьцаанд суурилсан урамшуулал | 7 | **328,950** | 361,926 | **1,259,125** | 1,401,172 |
| Санхүүгийн орлого | | **(49,725)** | (36,996) | **(105,650)** | (86,014) |
| Мөнгөн бус гадаад валют | | **3,274** | (2,553) | **1,184** | (22,453) |
| Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтаас үүссэн алдагдал | 4 | **2,995,481** | 644,607 | **5,079,912** | 901,623 |
| Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын хорогдолтын ашиг | 4 | **-** | - | **-** | (1,070,737) |
| Бэлэн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт | 6 | **(339,176)** | 192,762 | **(189,786)** | 1,224,984 |
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | **(1,178,519)** | (698,813) | **(2,570,698)** | (2,179,334) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | | |
| Опцион хэрэгжүүлснээс олсон орлого | 7 | **1,032,350** | 402,000 | **1,423,750** | 606,000 |
| Варрант хэрэгжүүлснээс олсон орлого | 7 | **-** | 397,499 | **-** | 397,499 |
| Түрээсийн өр төлбөрийн эргэн төлөлт | | **(1,874)** | (8,625) | **(1,874)** | (17,115) |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | **1,030,476** | 790,874 | **1,421,876** | 986,384 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | | | | |
| Хайгуул, хөрөнгийн үнэлгээний зардал | 5 | **(255,167)** | (73,996) | **(376,871)** | (214,240) |
| Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийн зардал | | **(9,621)** | (2,476) | **(6,892)** | (26,206) |
| Хүүгийн орлого | | **49,725** | 36,996 | **105,650** | 86,014 |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | **(215,063)** | (39,476) | **(278,113)** | (154,432) |
| Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө | | **(9,435)** | 2,837 | **(8,463)** | 25,277 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт | | **(372,541)** | 55,422 | **(1,435,398)** | (1,322,105) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд | | **6,235,542** | 2,972,072 | **7,298,399** | 4,349,599 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эцэст | | **$ 5,863,001** | $ 3,027,494 | **5,863,001** | $ 3,027,494 |

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг.

## 1. Үйл ажиллагааны тухай:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци ("Эрдэнэ Ресурс" "Корпораци" эсвэл "Компани" гэх) нь Канад Улсад төвтэй, үнэт болон суурь металлын хайгуул, хөгжүүлэлтийн үйл ажиллагааг Монгол Улсад эрхэлдэг. Компанийн голлох төсөл нь хараат компани болох Эрдэнэ Монгол ХХК-ийн эзэмшдэг Монгол Улсын Баянхонгор аймагт орших Баянхөндий алтны төсөл юм. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр "ERD", Монголын Хөрөнгийн Бирж дээр "ERDN" тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг нь 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1.

## 2. Тайлангийн үндэслэл

2025 оны 6 дугаар сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын аудитаар баталгаажаагүй хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайланг ("Хураангуй, завсрын үеийн санхүүгийн тайлан") Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт ("НББОУС") 34 - завсрын санхүүгийн тайлагналын дагуу боловсруулсан. Завсрын үеийн санхүүгийн тайлан нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-ийн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-ын дагуу боловсруулагдсан 2024 оны 12 дугаар сарын 31- нд дуусгавар болсон жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан ("Жилийн эцсийн санхүүгийн тайлан")-тай хамтад нь танилцах шаардлагатай.

Хураангуй, завсрын үеийн нэгтгэсэн санхүүгийн тайланг тайлагнахыг 2025 оны 8 дугаар сарын 11-ний өдөр ТУЗ зөвшөөрсөн.

## 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд

2025 оны 1 дүгээр сарын 1-ээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбар орж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Эдгээр өөрчлөлтүүдийг холбогдох шилжилтийн заалтуудын дагуу хийсэн.

<u>НББОУС 21 –Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөлөл</u>

2023 онд 8 сард НББОУС нь НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөөлөлд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэ нь аж хуйн нэгжүүдэд валют хоорондын хөрвөх чадварыг үнэлэх, хөрвөх чадвар хангалтгүй нөхцөлд бодит ханшийг тодорхойлох аргачлалыг сайжруулахад чиглэсэн. Энэхүү өөрчлөлт нь гадаад валютаар гүйлгээ хийдэг; үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид хамаарах бөгөөд тодорхой зорилготойгоор валют хөрвүүлэх боломжгүй нөхцөлд мөн хамааралтай. Валют нь хөрвөх боломжтойд тооцогдохын тулд бусад валютыг сольж авах боломжтой (зөвшөөрөгдсөн зохицуулалтын хүрээнд ердийн хоцрогдолтой байж болно) болон зах зээл эсвэл хөрвүүлгийн механизмын хүрээнд эрх, үүргийн дагуу солих нөхцөл бүрдсэн байх шаардлагатай. Компани нь нэмэлт өөрчлөлттэй холбоотой суурь өөрчлөлтүүдийг оруулсан бөгөөд Компанид материаллаг өөрчлөлт ороогүй.

*Доорх стандартыг нягтлан бодох бүртгэлд мөрдөгдөж эхлээгүй.*

<u>СТОУС 18 – Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга</u>

2024 оны 4 сарын 9-нд НББОУСЗ ("IASB") нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулгыг орлуулах зорилгоор СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга танилцуулсан. СТОУС 18 нь ашиг алдагдлын тайлангийн хүрээнд ангилал, тодорхойлсон дэд нийлбэр нэмж, удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүрүүдийн тодруулга, санхүүгийн тайлангийн мэдээллийг нэгтгэх, задлахыг сайжруулах шаардлагыг тусгасан. СТОУС 18-ын хүрээнд НББОУС 7-д нэмэлт өөрчлөлт оруулсан ба аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны орлогын дэд нийлбэрийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тайлагнах шууд бус аргаар эхлэл болгон ашиглах, мөн хүү, ногдол ашгийн төлбөрүүдийг төлсөн болон хүлээн авсан талаар тайлагнах хувилбаруудыг хасах шаардлагатай болсон. Үүнтэй адил НББОУС 33 "Нэгж хувьцаанд ногдох ашиг"-т нэмэлт өөрчлөлт оруулж, СТОУС 18-д нийт эсвэл дэд нийлбэрийн тоон үзүүлэлтээр ашиг, алдагдлын тайлангийн бусад бүрэлдэхүүн хэсгийг ашиглан нэгж хувьцаанд ногдох ашгийн нэмэлт мэдээллийг тодруулахыг зөвшөөрсөн. СТОУС 18 нь 2027 оны 1 сарын 1-ээс эхлэн тайлангийн үед хүчин төгөлдөр болох ба энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь дээрх стандартыг мөрдөж эхэлснээр гарах нөлөөллийг үнэлж байна.

**3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд (үргэлжлэл)**

<u>СТОУС 7 болон 9 - Санхүүгийн хэрэглүүр болон тодруулга</u>

2024 оны 5 сараас эхлэн НББОУСЗ (“IASB”) Санхүүгийн хэрэглүүрийн ангилал болон үнэлгээнд (СТОУС 7 болон СТОУС 9) нэмэлт өөрчлөлт оруулсан. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдээр СТОУС 9-ийн ангилал болон үнэлгээ, СТОУС 7-ийн холбогдох тодруулгын шаардлагыг шинэчилсэн. НББОУСЗ-өөс зарим санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, данснаас хасах хугацааг тодруулж, цахим төлбөрийн системийг ашиглан санхүүгийн өр төлбөрийг барагдуулахтай холбоотой шаардлагад өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлт нь 2026 оны 1 сарын 1-ээс эхлэн хүчин төгөлдөр болох ба энэхүү хугацаанаас өмнө даган мөрдөхийг зөвшөөрсөн. Компани нь дээрх стандартыг мөрдөж эхэлснээр гарах нөлөөллийг үнэлж байна.

**4. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт**

2023 оны 1 сарын 10-нд Компани нь Баянхөндий алтны төслийг хөгжүүлэх зорилгоор Монголиан Майнинг Корпорэйшн (“MMC”)-тэй стратегийн түншлэл болон хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсныг мэдээлсэн. Стратегийн түншлэлийн үндсэн нөхцөлүүдийг доор дурдав:

- MMC нь гурван үе шаттайгаар 40 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Хөндий, Алтан Нар ашиглалтын тусгай зөвшөөрөл, Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Эрдэнэ Ресурсийн Монгол дахь охин компани болох Эрдэнэ Монгол ХХК (“ЭМ”)-ын 50%-тай тэнцэх хувьцаанд хөрвөх нөхцөлтэй өрийн бичиг гаргасан.
- Эрдэнэ Ресурс нь Эрдэнэ Монгол ХХК-ийн 50%-г эзэмшихээс гадна Хөндий, Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн хүрээнд эхний 400,000 унц алтны олборлолтоос давсан олборлолт болон дээрх тусгай зөвшөөрлүүдийн орчимд 5 км-ийн талбайд эзэмших тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд 5%- ийн борлуулалтын орлогын төлбөр (“Net smelter return” буюу “NSR”) (цаашид “БОТ” гэх) авах нөхцөлтэй.

2024 оны 1 сарын 23-нд хөрвөх нөхцөлтэй өрийн бичгийг хөрвүүлсэнтэй холбогдуулан Эрдэнэ Монгол ХХК нь 50%-тай тэнцэх хувьцааг нэмж гарган, MMC-г хувь эзэмшигчээр бүртгэсэн. MMC нь Эрдэнэ Монголын хувьцааг захиалсан өдөр компани нь хөрвөх нөхцөлтэй өрийн бичгээр дамжуулан MMC-ийн Эрдэнэ Монголд оруулсан хөрөнгө оруулалтаас хамааруулж тооцсон Эрдэнэ Монголд үлдсэн $1,256,598 долларын хөрөнгө оруулалтыг бууруулсны ашгийг хүлээн зөвшөөрсөн. 2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон нэг жилийн хугацаанд компанийн хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтын өөрчлөлтийн хураангуйг доор харуулав.

| | | |
|---|---|---|
| Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт 2025.01.01 | $ | **53,109,742** |
| Хараат компанийн хяналт алдагдсанаас үүссэн алдагдал 2025.06. | | **(5,079,912)** |
| Гадаад валютын өөрчлөлтийн нөлөөлөл | | **(813,277)** |
| Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт 2025.06.30 | **$** | **47,216,553** |
| | | |
| Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт, 2024.01.01 | $ | 51,248,731 |
| Хараат компаниас орсон орлого, 2024.01.23 | | 54,073 |
| 2024.01.23 байдлаар тусгагдах ашиг | | 1,256,598 |
| Хараат компанийн хяналт алдагдсанаас үүссэн алдагдал, 2024.01 | | (3,299,182) |
| Гадаад валютын өөрчлөлтийн нөлөөлөл | | 3,849,522 |
| Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт 2024.12.31 | $ | 53,109,742 |

## 4. Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Дараах хүснэгтүүдэд Эрдэнэ Монгол ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн мэдээллийг 100% байдлаар харуулсан бөгөөд өмчийн аргаар бүртгэл хөтлөхөөр бодит үнэ цэнийн тохируулгыг тусгасан. Эрдэнэ Монгол ХХК-ийн хураангуй санхүүгийн мэдээллийг компанийн хөрөнгө оруулалтын бүртгэлтэй нийцүүлсэн мэдээллийг доорх хүснэгтээс харна уу:

| Хугацаанд | 6 сарын 30 2025 | 12 сарын 31 2024 |
|---|---|---|
| Нийт эргэлтийн хөрөнгө | **$ 21,728,090** | $ 26,826,631 |
| Нийт эргэлтийн бус хөрөнгө | **231,416,016** | 190,020,662 |
| Нийт богино хугацаат өр төлбөр | **(13,308,635)** | (6,993,430) |
| Нийт урт хугацаат өр төлбөр | **(145,402,365)** | (103,634,379) |
| Нийт хөрөнгө | **$ 94,433,106** | $ 106,219,484 |

| | 2025.06.30-нд дуусгавар болсон 6 сар | 2024.12.31-нд дуусгавар болсон 1 жил |
|---|---|---|
| Орлого | **$ -** | $ - |
| Нийт алдагдал | **10,159,823** | 6,541,648 |

| хугацаанд | 6 сарын 30 2025 | 12 сарын 31 2024 |
|---|---|---|
| Эрдэнэ Монголын нийт хөрөнгө | **$ 94,433,106** | $ 106,219,484 |
| Эрдэнэ Ресурсийн хувь хэмжээ | **50.00%** | 50.00% |
| Эрдэнэ Ресурс-д ногдох нийт хөрөнгө | **47,216,553** | 53,109,742 |
| Эрдэнэ Монгол дахь хөрөнгө оруулалтын үлдэх өртөг | **47,216,553** | 53,109,742 |

## 7. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

Зуун Мод төсөл нь Монгол Улсын Баянхонгор аймагт 6,041 га талбайг хамардаг бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд олгосон. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд 20 жилээр 2 удаа сунгах боломжтой.

2024 оны 12 сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн болон 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд Компанийн хайгуул, үнэлгээний хөрөнгөд үүссэн өөрчлөлтийг доорх хүснэгтэд харуулав.

| | 2025.06.30 | 2024.12.31 |
|---|---|---|
| 1 сарын 1-ний байдлаар | **2,468,070** | 1,961,506 |
| Нэмэгдэл | **376,871** | 348,887 |
| Валютын ханшийн шилжилтийн нөлөө | **(205,765)** | 157,677 |
| | **2,639,176** | 2,468,070 |

## 6. Нэмэлт мөнгөн урсгалын мэдээлэл

| | 6.30-нд дуусгавар болсон 3 сар | | 6.30-нд дуусгавар болсон 6 сар | |
|---|---|---|---|---|
| | **2025** | **2024** | **2025** | **2024** |
| Бэлэн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт | | | | |
| Авлага | **$ (311,014)** | $ 180,503 | **$ (341,266)** | $ (129,126) |
| Урьдчилж төлсөн зардлууд | **(172,078)** | (55,550) | **(183,745)** | 1,147,071 |
| Арилжаа болон бусад өглөг | **143,916** | 67,809 | **335,225** | 207,039 |
| | **$ (339,176)** | $ 192,762 | **$ (189,786)** | $ 1,224,984 |

## 7. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө оруулалт

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

Варрант

2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд варрант хэрэгжүүлээгүй (2024 – 883,330 варрантыг хэрэгжүүлж $397,499-ын орлого төвлөрүүлсэн).

Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр болон Залгамж халааны төлөвлөгөө

2023 оны 6 сарын 22-ны өдөр Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр” (“ХСУБХ” буюу “Omnibus plan”) баталсан. ХСУБХ нь опцион (“Опцион” буюу “Options”), хязгаарлалт бүхий хувьцааны нэгж ("ХБХН” буюу ”RSUs”) гүйцэтгэлд суурилсан хувьцааны нэгж (“ГСХН” буюу “PSUs”) ирээдүйд олгогдох хувьцааны эрх (“ИОХЭ” буюу “DSUs”) зэрэг хувьцаанд суурилсан урамшууллыг харьцангуй уян хатан байдлаар компани болон охин компаниудын захирал зөвлөхүүд, ажилтнуудад олгон, урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ. ХСУБХ нь батлагдсанаар Залгамж халааны төлөвлөгөө болох хувьцаанд суурилсан опционы төлөвлөгөө, ИОХЭ-ийн төлөвлөгөөг орлоно. Тус төлөвлөгөөнүүдийн дагуу олгогдсон урамшуулал нь хүчин төгөлдөр хугацаа дуусгавар болтол хүчинтэй.

ХСУБХ нь хувьсах төлөвлөгөө бөгөөд тус хөтөлбөрийн дагуу олгосон энгийн хувьцааний тоо хэмжээ нь (Залгамж халааны төлөвлөгөөгөөр олгосон урамшууллыг багтаасан) Компанийн гаргасан болон арилжиж буй энгийн хувьцааны нийт хэмжээний 10%-иас хэтрэхгүй байх ёстой.

2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд Компани хувьцаанд суурилсан урамшууллын $1,259,125 зардлыг нэгтгэсэн алдагдалд зарлагадсан (2024 – $1,401,172) ба ХСУБХ болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгосон опцион болон ИОХЭ-ийн бодит үнэлгээг тусгасан. ХСУБХ болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу олгогдсон урамшууллын дэлгэрэнгүй мэдээллийг дор харуулав:

Хувьцааны опцион

Компани нь хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөр болон залгамж халааны төлөвлөгөөний дагуу Компанийн ТУЗ-ийн гишүүд, удирдлага, ажилтан албан тушаалтнуудад компанийн хувьцааг худалдан авах боломж бүхий опционыг олгодог. Опционыг хэрэгжүүлэх, олгох нөхцөлүүдийг ТУЗ тодорхойлно. Одоогоор хэрэгжүүлэх боломжтой опцион нь олгогдсон даруйдаа хүчинтэй болсон.

2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд $0.67 жигнэсэн дундаж ханш бүхий 3,375,000 опционыг олгосон (2024 – $0.30 жигнэсэн дундаж ханш бүхий 5,680,000 опцион олгогдсон). 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд дунджаар $0.39 ханшаар нийт үнэлгээ нь $1,423,750 бүхий 3,615,000 опцион хэрэгжүүлсэн (2024 – $0.23 дундаж ханшаар нийт үнэлгээ нь $606,000 бүхий 2,660,000 опцион хэрэгжүүлсэн). 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд опционы хугацаа дуусаагүй (2024 – 315,000 опционы хугацаа дууссан)

2024 болон 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын байдлаар үнэт цаасны опционд гарсан өөрчлөлтүүд:

## 7. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

| | 2025.06.30 | | | 2024.06.30 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **Опционы тоо** | | **Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж ханш** | **Опционы тоо** | | **Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж ханш** |
| 1 сарын 1-ний байдлаар | **22,445,000** | **$** | **0.35** | 20,485,000 | $ | 0.35 |
| Олгосон | **3,375,000** | | **0.67** | 5,680,000 | | 0.30 |
| Хугацаа дууссан | **-** | | **-** | (315,000) | | 0.39 |
| Хэрэгжүүлсэн | **(3,615,000)** | | **0.39** | (2,660,000) | | 0.23 |
| 6 сарын 30-ны байдлаар | **22,205,000** | **$** | **0.39** | 23,190,000 | $ | 0.35 |
| 6 сарын 30-ны байдлаар хэрэгжүүлэх боломжтой | **22,205,000** | **$** | **0.39** | 23,190,000 | $ | 0.35 |

2024 болон 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд гаргасан опционы үнэ цэнийг опцион гаргах үед Блэк Шолсийн опционы үнэлгээний загварыг ашиглан, жигнэсэн дундаж үнээр тогтоосон:

| | 2025.06.30 | | 2024.06.30 | |
|---|---|---|---|---|
| Гаргах өдрийн хувьцааны үнэ | **$** | **0.66** | $ | 0.33 |
| Хэрэгжүүлэх үнэ | **$** | **0.67** | $ | 0.30 |
| Эрсдэлгүй хүүгийн түвшин | | **2.6%** | | 3.8% |
| Хүлээгдсэн хугацаа | | **4.3 жил** | | 4.6 жил |
| Хүлээгдсэн хэлбэлзэл | | **53%** | | 54% |
| Хүлээгдсэн ногдол ашиг | | **0.0%** | | 0.0% |
| Гаргах өдрийн зах зээлийн жигнэсэн дундаж үнэ | **$** | **0.29** | $ | 0.17 |

Хүлээгдсэн хэлбэлзлийг үнэт цаасны түүхэн ханшийн хэлбэлзлийг харгалзан тооцсон.

2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд гаргасан опцион нь хувьцаанд суурилсан урамшуулал ба захиргааны зардалд $967,625 (2024 – $939,500) долларын зардал хэлбэрээр тусгагдсан.

<u>Ирээдүйд олгогдох хувьцааны эрх (“ИОХЭ” буюу “DSU”)</u>

2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд компани нь олгогдох өдрийн өмнөх 5 хоногийн жигнэсэн дундаж ханш нь $0.73 бүхий 401,083 ИОХЭ олгогдсон (2024 – нэгж бүр нь $0.37 ханш бүхий 1,241,733 ИОХЭ олгогдсон). Бодит үнэлгээ нь $291,500 (2024 – $461,672) бүхий ИОХЭ нь Захиргаа, удирдлагын зардал болон хайгуулын зардалд тусгагдсан.

Олгосон өдрөөс ирээдүйд олгогдох хувьцааны эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой. Хугацаа дуусгавар болох, эсвэл хөтөлбөрт хамрагдсан гишүүн нас барсан тохиолдолд Компани тухайн гишүүний хувийг бэлэн мөнгөөр эсвэл үнэт цаасаар зах зээлийн үнэлгээгээр худалдан авах боломжтой. Энэ нь Компанийн сонголтоор хийгдэх бөгөөд Компани бэлэн мөнгөөр худалдан авахгүйгээр шийдвэрлэвэл энэхүү төлөвлөгөө нь үнэт цаасанд суурилсан хөтөлбөрт шилжинэ. 2023 оны 6 сарын 22-нд батлагдсан хувьцаанд суурилсан урамшууллын багц хөтөлбөрийн төлөвлөгөө дэх ИОХЭ-ийн нөхцлүүд нь хуучин хэрэгжиж байсан ИОХЭ-ийн хөтөлбөрийн заалтуудтай нийцэж байна.

2024 болон 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд ИОХЭ-ийн мэдээллийг доор харуулав.

## 7. Хувьцаат капитал, нэмэлт хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

| | 2025.06.30 | 2024.06.30 |
|---|---|---|
| | Тоо ширхэг | Тоо ширхэг |
| 1 сарын 1-ний байдлаар | **9,991,248** | 8,442,250 |
| Олгосон | **401,083** | 1,241,733 |
| 12 сарын 31-ний байдлаар | **10,392,331** | 9,683,983 |

## 8. Хайгуул болон үнэлгээний зардал

2024, 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав ба зургаан сарын хугацаанд хайгуул болон үнэлгээний зардлын мэдээллийг доор хүснэгтэд харуулав:

| | 6.30-нд дуусгавар болсон 3 сар | | 6.30-нд дуусгавар болсон 6 сар | |
|---|---|---|---|---|
| | 2025 | 2024 | 2025 | 2024 |
| Шууд зардал | **$ 163,378** | $ 123,741 | **$ 272,864** | $ 299,453 |
| Ажилтнуудын урамшуулал | **406,696** | 574,861 | **1,248,195** | 1,060,297 |
| Хувьцаанд суурилсан урамшуулал | **240,750** | 165,179 | **571,500** | 518,129 |
| Хараат компаниас нөхөн төлсөн | **(296,600)** | (267,191) | **(604,745)** | (498,133) |
| | **$ 514,224** | $ 596,590 | **$ 1,487,814** | $ 1,379,746 |

Компани болон хараат компани нь геологийн үйлчилгээ үзүүлсний хүрээнд суутгах татварыг хасч тооцсон жилд нэг сая ам.долларыг нөхөн төлөх гэрээтэй.

## 9. Захиргаа, удирдлагын зардал

2024, 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын хугацаанд захиргаа, удирдлагын зардлын мэдээллийг дор харуулав:

| | 6.30-нд дуусгавар болсон 3 сар | | 6.30-нд дуусгавар болсон 6 сар | |
|---|---|---|---|---|
| | 2025 | 2024 | 2025 | 2024 |
| Захиргааны үйлчилгээ | **$ 262,883** | $ 260,275 | **$ 802,333** | $ 678,017 |
| ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуул | **32,500** | 39,151 | **60,000** | 70,401 |
| Санхүүжилтийн зардал | **-** | - | **-** | 1,269,124 |
| Хөрөнгө оруулагчтай харилцах, ма | **57,168** | 41,209 | **133,371** | 149,084 |
| Оффис ба бусад | **24,315** | 20,254 | **61,891** | 56,537 |
| Мэргэжлийн үйлчилгээний төлбөр | **123,446** | 71,367 | **212,392** | 161,665 |
| Зохицуулагч байгууллагын төлбөр, | **58,359** | 26,499 | **130,425** | 90,173 |
| Хувьцаанд суурилсан урамшуулал | **88,200** | 196,747 | **687,625** | 883,043 |
| Томилолтын зардал | **11,482** | 11,528 | **71,171** | 86,574 |
| | **$ 658,353** | $ 667,030 | **$ 2,159,208** | $ 3,444,618 |

## 10. Холбогдох талууд

Компанийн голлох удирдах ажилтнуудад ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх албан тушаалтнууд багтдаг. Эдгээр голлох удирдлагын ажилтнуудын цалин урамшууллыг доор харуулав:

2024 болон 2025 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын тайлан

| | 6 сарын 30-нд дуусгавар болсон 6 сар | | | |
|---|---|---|---|---|
| | | **2025** | | **2024** |
| ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал | **$** | **60,000** | $ | 61,500 |
| ТУЗ-ийн гишүүдийн хувьцаанд суурилсан урамшуулал | | **307,050** | | 491,000 |
| Ажилтнуудын цалин урамшуулал | | **1,171,608** | | 1,131,422 |
| Удирдах албан тушаалтнуудын хувьцаанд суурилсан урамшуулал | | **427,250** | | 562,018 |
| | **$** | **1,965,908** | $ | 2,245,940 |

## 12. Тайлант хугацааны үйл явдлууд

2025 оны 7 сарын 2-нд компани нь Оюу Толгой ордоос баруун урд зүгт 10 км-т орших зэс, алтны порфирийн хэтийн төлөв бүхий Тэрэг Уул талбайн 80% хүртэл эзэмших эрхийг олж авах гэрээ байгуулсан. Гэрээний нөхцлөөр Эрдэнэ Ресурс нь 12 сарын хугацаанд 300,000 ам.долларыг хайгуулын зардалд зарцуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигч ("option grantor")-д 200,000 ам.долларын төлбөр төлөх үүрэг хүлээнэ. Тус гэрээний нэг, хоёр болон гурав дахь жилийн ойд Компани нь 400,000; 500,000 болон 900,000 ам.долларын төлбөрийг төлөх нөхцөлтэй бөгөөд хайгуулын үйл ажиллагаанд 3,000,000 ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ. Компани нь гэрээ зурагдсанаас хойш гурав болон дөрөв дэх жилийн хооронд тусгай зөвшөөрөл эзэмшигчид 5 сая ам.долларын төлбөрийг төлснөөр Тэрэг Уул Майнс ХХК-ийн 51%-ийг эзэмших эрхтэй болно. Эрдэнэ Ресурс нь нэмэлтээр 10 сая ам.долларыг хайгуул, үнэлгээний зардалд зарцуулж, гэрээ зурагдсанаас хойш 8 дахь жилд, эсвэл түүнээс өмнө 8 сая ам.долларын нэмэлт төлбөрийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид төлснөөр Тэрэг Уул Майнс ХХК-ийн 80 хүртэл хувийг эзэмших боломжтой. Гэрээ хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд компани нь бүх хайгуулын үйл ажиллагааг удирдан гүйцэтгэх бөгөөд аль ч хугацаанд торгуульгүйгээр гэрээг цуцлах эрхтэй.

*Орчуулга: Энэхүү тайлан нь англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.*